

Компанийн засаглалын үнэлгээний асуулга					
<i>Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана..</i>					
НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ					
ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна					
№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	Хэрэгжүүлсэн	“Сүү” ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн 21 тоот тогтоолоор баталсан “ТУЗ-ийн Үйл ажиллагааны журам”-д тусгасан. “Сүү” ХК-ийн Suu.mn веб сайтын Хөрөнгө оруулагч цэсний Бичиг баримт хэсэгт байршуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Түүнчлэн 2025 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийг, нотлох баримтуудын хамт хавсаргав.	2	100
2	1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.	Хэрэгжүүлсэн	“Сүү” ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 11 сарын 14-ний өдрийн №21 тоот тогтоолын 08 дугаар хавсралт, 2023 оны 01 сарын 16-ны өдрийн тогтоолын хавсралтаар тус тус баталсан “Залгамж халааны бодлого, нэр дэвшүүлэх журам”-тай бөгөөд “Сүү” ХК-ийн Suu.mn веб сайтын Хөрөнгө оруулагч цэсний Бичиг баримт хэсэгт байршуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	2	100
3	1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.	Хэрэгжүүлсэн	2025 оны Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсан бөгөөд өөрийн цахим хуудсанд байршуулсан. ТУЗ-ийн дарга, гишүүдийн жилийн ажлын гүйцэтгэлийг үнэлсэн ба хавсаргав.	2	100
4	1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол,	Хэрэгжүүлсэн	2024 оны 04 сарын 16-ны өдрийн №08 тоот ТУЗ-ийн тогтоолын дагуу Нэр дэвшүүлэх журамд “ТУЗ-ийн бүрэлдэхүүний аль нэг хүйсийн эзлэх хувийг гучаас доошгүй байх зорилтыг” тавин,	2	100

	мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.		нэмэлт өөрчлөлд оруулж, баталсан бөгөөд “Сүү” ХК-ийн Suu.mn веб сайтын Хөрөнгө оруулагч хэсэгт байршуулсан.		
5	1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	Хэрэгжүүлсэн	“Сүү” ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн 21 тоот тогтоолоор баталсан “ТУЗ-ийн Үйл ажиллагааны журам”-д тусгасан. 2025 оны сургалт хөгжлийн төлөвлөгөө болон гүйцэтгэлийн тайланг хавсаргав.	2	100
6	1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	Хэрэгжүүлсэн	“Сүү” ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн 21 тоот тогтоолоор баталсан “ТУЗ-ийн Үйл ажиллагааны журам”-д тусгасан. 2025 оны батлагдсан төлөвлөгөө болон ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг хавсаргав.	2	100
ДҮН				12	100
ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ					
7	2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	Хэрэгжүүлсэн	1/3 нь хараат бус гишүүн байх бөгөөд хороодын 2/3 нь буюу олонх нь хараат бус гишүүнтэй. Түүнчлэн “Нэр дэвшүүлэх журам”-д 2024 оны 04 сарын 16-ны өдрийн №08 тоот ТУЗ-ийн тогтоолоор “ТУЗ-ийн дарга болон гишүүдийн олонхыг хараат бус болгох зорилтыг” нэмэлт өөрчлөлд оруулсан. “Сүү” ХК-ийн Suu.mn веб сайтын Хөрөнгө оруулагч хэсгийн Бичиг баримт хэсэгт байршуулж хэрэгжүүлж байна. 2025 оны 04 сарын 22-ны өдрийн “Сүү” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүд /1 гишүүн өөрчлөгдсөн/-ийг сонгосон ба СЗХ, МХБ-д хагас жилийн тайланд мэдээллийг хүргүүлсэн. ТУЗ-ийн 2025 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 21 дугаар тогтоолоор НБД-ыг өөрчлөн томилсон ба МХБ-д мэдэгдсэн. НБД-ийн томилсон тушаалыг хавсаргав.	2	100

8	2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	Хэрэгжүүлсэн	2023.05.01-ний өдрийн 10-1 тоот ТУЗ-ийн тогтоолоор баримт бичиг баталсан ба 2023 оны 06 сарын 30-ны өдрийн №20-1 тоот ТУЗ-ийн тогтоолын дагуу Аудитын хорооны дарга хараат бус этгээд байдаг. “Сүү” ХК-ийн Suu.mn веб сайтийн Хөрөнгө оруулагчид цэсний Төлөөлөн удирдах зөвлөл хэсэгт байршуулсан. 2025.01.07-ны өдөр хороод, НБД тайлангаа гаргаж, СЗХ, Биржид илгээн, 2025.04.22-ны өдрийн ХЭХуралд дэлгэрэнгүй танилцуулсан. 2025 оны жилийн эцсийн ТУЗ-ийн хороодын тайлан болон НБД-ын тайланг илгээв.	2	100
9	2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.	Хэрэгжүүлсэн	2022.11.14-ний өдрийн 21 тоот ТУЗ-ийн тогтоолоор баталсан. “Сүү” ХК-ийн Suu.mn веб сайтын Хөрөнгө оруулагч цэсний Бичиг баримт хэсэгт байршуулсан.	2	100
10	2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Хэрэгжүүлсэн	2022.11.14-ний өдрийн 21 тоот ТУЗ-ийн тогтоолоор тогтоолоор баталсан бөгөөд “Сүү” ХК-ийн Suu.mn веб сайтын Хөрөнгө оруулагч цэсний Бичиг баримт хэсэгт байршуулсан.	2	100
11	2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	Хэрэгжүүлсэн	Бусад чиг үүрэг бүхий хороо байхгүй боловч ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд нэмэлт зохицуулалт тусгасан бөгөөд “Сүү” ХК-ийн Suu.mn веб сайтад байршуулсан.	2	100
ДҮН				10	100
ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ					

ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана					
12	3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Хэрэгжүүлсэн	2025 оны 03 сарын 06-ны өдрийн ТУЗ-ийн №07 тоот тогтоолоор Дотоод аудитыг томилж, аудитын дүрмийг баталсан бөгөөд “Сүү” ХК-ийн Suu.mn веб сайтад байршуулсан. Хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Материалыг хавсаргав.	2	100
13	3.2. ТУЗ нь энэхүү кодекс заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Хэрэгжүүлсэн	Биржээр дамжуулан хүргэдэг бөгөөд нэмэлтээр Suu.mn-д байршуулсан. ХЭХуралд мөн танилцуулсан. Хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хурлын материалыг хавсаргав.	2	100
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.	Хэрэгжүүлсэн	“Сүү” ХК-ийн Suu.mn веб сайтад байршуулсан. Хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	2	100
ДҮН				6	100
ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО					
ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана					
15	4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Хэрэгжүүлсэн	2023 оны 05 сарын 01-ний өдрийн тогтоолын хавсралтаар Аудитын хорооны журам баталсан бөгөөд 2025 оны 03 сарын 06-ны өдрийн ТУЗ-ийн №07 тоот тогтоолоор Дотоод аудитыг томилж, аудитын дүрмийг шинэчлэн баталсан “Сүү” ХК-ийн Suu.mn веб сайтад байршуулсан. Хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Материалыг хавсаргав.	2	100
16	4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.	Хэрэгжүүлсэн	2025.04.22-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, мэдээлэл хүргэсэн. Хурлын РРТ-г хавсаргав.	2	100
17	4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц,	Хэрэгжүүлсэн	Компанийн үйл ажиллагааны тайланд тусгаж, Хувьцаа	2	100

	зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.		эзэмшигчдийн хуралд танилцуулсан бөгөөд “Сүү” ХК-ийн албан ёсны веб сайт Suu.mn сайтад байршуулсан.		
ДҮН				6	100
ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА					
ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина					
18	5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Хэрэгжүүлсэн	2023.05.29-ний өдрийн 17 тоот ТУЗ-ийн тогтоолоор батлагдсан. “Сүү” ХК-ийн Suu.mn веб сайтад байршуулсан бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	2	100
19	5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.	Хэрэгжүүлсэн	Гишүүдийн 2/3 нь хараат бус бөгөөд хорооны тайланг хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнаж, “Сүү” ХК-ийн Suu.mn веб сайтад байршуулсан.	2	100
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	Хэрэгжүүлсэн	БОНЗ тайланг МХБ-д тайлагнаж, өөрийн Suu.mn сайтад байршуулсан бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнасан. МХБ-ийн журмын дагуу 2026 оны эхний улиралд багтаан тайлагнах ажлыг бэлдэж байна.	2	100
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Хэрэгжүүлсэн	“Сүү” ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 17 тоот тогтоолоор “Комплаенсын хяналтын зааврыг” баталсан. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн, ХЭХуралд танилцуулсан ба материал болон БОНЗ тайланг	2	100

			МХБ-д тайлагнаж, өөрийн Suu.mn сайтад байршуулсан.		
ДҮН				8	100
ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ					
Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна					
22	6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцээж батална.	Хэрэгжүүлсэн	2025 оны 04 сарын 22-ны өдрийн ХЭХурлаар хэлэлцэж, баталсан. Тогтоол №04	2	100
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.	Хэрэгжүүлсэн	Сүү ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 21 тоот тогтоолоор батлагдсан.	2	100
24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	Хэрэгжүүлсэн	2025 оны Хувьцаа эзэмшигчдийн хуралд Гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг хамт тусгаж Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсан. Мөн цахим хуудаснаа байршуулсан.	2	100
ДҮН				6	100
ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ					
Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ					
25	7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	Хэрэгжүүлсэн	2023 оны 03 сарын 29-ний өдрийн №08 тоот ТУЗ-ийн тогтоолын хавсралтаар батлагдаж мөрдөн ажиллаж байна. /Suu.mn байршуулсан/	2	100
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	Хэрэгжүүлсэн	2024 оны жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажилласан тайланг тусгаж, компанийн цахим хуудсанд байршуулсан. 2025 оны жилийн үйл ажиллагааны тайланг олон нийтэд танилцуулах ажил бэлтгэж байна.	2	100

27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	Хэрэгжүүлсэн	Suu.mn хаягт кодексд заасан шаардлагатай мэдээллийг өөрийн цахим хуудаснаа байршуулсан.	2	100
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Хэрэгжүүлсэн	Компанийн ёс зүйн дүрэм, Сургалт хөгжлийн журам, Дотоод журамд тусгагдсан. Мөн “Сүү” ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 27 дугаар тогтоолоор “Шүгэл үлээх журам” батлагдаж хэрэгжилтийг хангуулах ажлыг бэлдэж байна.	2	100
ДҮН				8	100
НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ					
ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно					
29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Хэрэгжүүлсэн	2022 оны 11 сарын 14-ний өдрийн №21 тоот ТУЗ-ийн тогтоолын хавсралтаар баталсан. /Suu.mn байршуулсан./	2	100
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.	Хэрэгжүүлсэн	2022.11.14-ний өдрийн 21 тоот ТУЗ-ийн тогтоолоор батлагдсан /Комплайнсын хяналтын зааварт тусгагдсан./ /Suu.mn байршуулсан./ Мөн “Сүү” ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 27 дугаар тогтоолоор “Шүгэл үлээх журам” батлагдаж хэрэгжилтийг хангуулах ажлыг бэлдэж байна.	2	100
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	Хэрэгжүүлсэн	2022 оны 11 сарын 14-ний өдрийн №21 тоот ТУЗ-ийн тогтоолын хавсралтаар баталсан. /Suu.mn байршуулсан/	2	100
ДҮН				6	100
ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ					
Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана					
32	9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн	Хэрэгжүүлсэн	Өөрийн цахим шуудсаар дамжуулан шаардлагатай мэдээллүүдийг хүргэж байна. /Suu.mn “Хөрөнгө оруулагчдад” хэсэг/	2	100

	талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.				
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	Хэрэгжүүлсэн	2023 оны 03 сарын 29-ний өдрийн №08 тоот ТУЗ-ийн тогтоолын хавсралтаар батлагдаж мөрдөн ажиллаж байна. /Suu.mn байршуулсан./	2	100
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.	Хэрэгжүүлсэн	2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг танхимаар зохион байгуулж, санал өгөх, мэдээлэл авах, асуулт асуух боломжийг олгосон.	2	100
35	9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.	Хэрэгжүүлсэн	2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг танхимаар зохион байгуулж, санал өгөх боломжийг цаасан болон программын тусламжтайгаар олгосон.	2	100
36	9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.	Хэрэгжүүлсэн	2022.11.14-ний өдрийн 21 тоот ТУЗ-ийн тогтоолоор шинэчлэн батлагдсан. 2025.02.26-ны өдрийн №05, 2025.05.12-ны өдрийн №13 тоот ТУЗ-ийн тогтоолоор сонирхлын зөрчилтэй хэлцлийг баталсан ба тухай бүр мэдээллэж, МХБ-н сайтад байршуулсан.	2	100
ДҮН				10	100
НЭГДСЭН ДҮН				70	100

Тайлан боловсруулсан:

Үнэт цаас, комплаенс хариуцсан менежер

Б.Үенч

Тайлан хянасан:

Гүйцэтгэх захирал

Б.Гантулга

